



**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

┌
Эмнэлгийн аюултай хог хаягдлыг
ангилах, цуглуулах, түр хадгалах, халдваргүйтгэх,
тээвэрлэх, устгах журам батлах тухай
└

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” 505 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сэргээн засах төвийн “Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, зөөвөрлөх, түр хадгалах, тээвэрлэх устгах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг нийт эмч ажилтнуудад, мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Халдвар хяналтын багийн ахлагч /Н.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Халдвар хяналтын багийн ахлагч /Н.Эрдэнэчимэг/, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багийн ахлагч /Н.Дарьсүрэн/, ахлах сувилагч нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.САРУУЛТУЯА

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 08 сарын 01 өдрийн
... дугаар тушаалын ... хавсралт



**СЭРГЭЭН ЗАСАХ ТӨВИЙН ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ
АНГИЛАН ЯЛГАХ, ЦУГЛУУЛАХ, ЗӨӨВӨРЛӨХ, ТҮР ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ
УСТГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 505 дугаар тушаалыг хэрэгжүүлэх, эмнэлгийн хог хаягдлын менежментийг стандартын түвшинд явуулах
- 1.2. Сэргээн засах төвийн аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, зөөвөрлөх, түр хадгалах, тээвэрлэх устгахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулах, стандартын шаардлага хангасан хог хаягдлыг ангилж, цуглуулах, устгах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Аюултай хог хаягдлыг ангилан ялгах

- 2.1. Тасгийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан нь аюултай хог хаягдлыг заавар журмын дагуу эх үүсвэр дээр нь зөв ангилж цуглуулан хар, шар, хүрэн тэмдэглэгээтэй уут, сав, аюулгүй хайрцагт хийнэ.
- 2.2. Хар өнгийн тэмдэглэгээтэй хогийн сав, уутанд энгийн хог хаягдлыг хийнэ. Үүнд: Албан тасалгаа, үйлчилгээний өрөө, бие засах газар, гал тогоо, агуулах, хонгил, орчны эдэлбэр газраас гарч буй сав, баглаа боодол, гар угаасны дараа хэрэглэсэн нэг удаагийн алчуур, эм, урвалжийн гадна талын сав баглаа боодол, нэг удаагийн зүүний хуванцар таглаа (бохирлогдоогүй) хоол хүнсний үлдэгдэл зэрэг хаягдлуудаас гадна шил, цаас, цаасан хайрцаг, хаягдал төмөр болон төрөл бүрийн хуванцар зэрэг ашиглаж болох дахивар нөөц хамаарна.
- 2.3. Шар өнгийн тэмдэглэгээтэй хогийн сав, уутанд халдвартай хог хаягдлыг хийнэ. Үүнд: Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад биологийн шингэнээр (биеийн өтгөн, шингэн ялгадас, цэр, шүлс, цус) бохирлогдсон зүйлс, цус, цусан бүтээгдэхүүн болон лабораторид үүсэх хүн, амьтанд халдвар дамжуулах эрсдэл бүхий эмгэг төрөгчөөр бохирлогдсон өсгөвөр, тэжээлт орчин, тэдгээрийг хэрэглэхэд ашиглагдаж буй багаж хэрэгсэл, вакцин, биобэлдмэл, судалгаа шинжилгээнд ашигласан туршилтын мал,

амьтны сэг зэм гэх мэт хог хаягдал хамаарна. Мөн эмгэг хог хаягдал болох мэс ажилбар, задлан шинжилгээний явцад гарсан биеийн хэсэг, хавдрын ургацаг, зулбадас хамаарна.

- 2.4. Аюулгүй хайрцганд хурц үзүүртэй, иртэй хог хаягдлуудыг хийнэ. Үүнд: Халдвартай эсэхээс үл хамааран хатгах, зүсэх гэмтэл учруулах эрсдэлтэй бүх төрлийн зүү, тариур, өндөг цоологч, наалдацын шил, мэс заслын хутга, ир, хагарсан ампул, түүнтэй адилтгах шилэн эд зүйл, пипетка, хуруу шил гэх мэт бүх төрлийн хог хаягдал хамаарна.
- 2.5. Хүрэн өнгийн тэмдэглэгээтэй хогийн сав, уутанд эмийн болон эсэд хортой хог хаягдалыг хийнэ. Үүнд: Хугацаа дууссан, хэрэглэхийг хориглосон, хагарч гэмтсэн, бохирдсон эм, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис агуулсан сав, тун шил, хайрцаг зэрэг нь эмийн хог хаягдалд, хавдрын эмчилгээний үед хэрэглэгддэг эсэд хортой нөлөө үзүүлдэг эм, эмийн үлдэгдэл, тэдгээрийг агуулж байсан сав, тун шил, хайрцаг, хэрэглэсэн зүү, тариур зэрэг нь эсэд хортой эмийн хог хаягдалд хамаарна. Бусад төрлийн хог хаягдалтай хольж болохгүй.
- 2.6. Химийн бодисын хог хаягдалд эрүүл мэндийн байгууллагын оношилгоо эмчилгээ, шинжилгээ, судалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагааны явцад үүссэн хатуу, шингэн, хийн байдалтай химийн бодисууд, хүнд металл агуулсан хэрэгслүүд хамаарна. Үүнд:
- Лабораторийн хаягдал (урвалж оношлуур, химийн бодисын хаягдал
- г.м.
- Уусгагч,
 - Рентген зургийн хальс бэхжүүлэх, боловсруулах уусмал,
 - Формальдегид, этилөн оксид,
 - Хугацаа дууссан химийн бодисууд,
 - Шингэн хий агуулж байсан сав, бортого
 - Хэрэглээнээс гарсан халууны шил, даралтны аппарат
 - Эмнэлгийн зарим төрлийн багаж хэрэгсэл,
 - Өдрийн гэрэл, зай зэрэг болно.
- 2.7. Зөөх, тээвэрлэх нөхцлийг хангасан, түгжээтэй, бат бөх тугалган хамгаалалт бүхий зориулалтын саванд цацраг идэвхит хог хаягдлыг хийнэ. Үүнд: Цацраг идэвхит хог хаягдалд эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, судалгааны ажлын

явцад үүсэх ионжуулагч цацраг бүхий радионуклидууд агуулсан цацраг идэвхит шинж чанар бүхий хатуу, шингэн, хийн хаягдал хамаарна.

Гурав. Хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх

- 3.1. Хог хаягдлын уут нь Эрүүл мэндийн сайдын 505 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын хоёрт заасан шаардлага хангасан байна.
- 3.2. Эмнэлгийн гаралтай хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх үйлчлэгч нарыг улирал бүр хог хаягдалын менежментийн сургалтанд хамруулна.
- 3.3. Халдвар хяналтын багийн ахлагч хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх үйлчлэгч нарыг үүрэгжүүлж, тогтмол хяналт тавьж ажиллана.
- 3.4. Кабинет бүр үүссэн эмнэлгийн гаралтай хог хаягдлыг зөөвөрлөхийн өмнө тасаг, нэгжийн нэр, хог хаягдал үүссэн огноо бичсэн хаягжилтыг уутны гадна талд тогтоон байрлуулж, эмнэлгийн аюултай хог хаягдал хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.
- 3.5. Тасаг, кабинетүүдэд үүссэн аюултай хог хаягдлыг давхар бүрт байрлах аюултай хог хаягдлыг цуглуулах сав, тэргэнцэрт цуглуулна.
- 3.6. Аюултай хог хаягдал зөөвөрлөх дугуйтай тэргэнцэрт зөвхөн 1,2-р давхарт байрлах кабинетүүдын эмнэлгийн гаралтай хог хаягдлыг хийж зөөвөрлөнө. Цахилгаан шатгүй нөхцөлд 3,4 давхарт байрлах кабинетүүдийн аюултай хог хаягдлыг барьж явах зориулалт бүхий саванд цуглуулна.
- 3.7. Хог хаягдал зөөвөрлөх нөөц сав, тэргэнцэртэй байна.
- 3.8. Маршрутын дагуу аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан эмнэлгийн хог хаягдал түр хадгалах цэг рүү зөөвөрлөнө.
- 3.9. Үйлчлэгч нар ахуйн хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт хаяна.

Дөрөв. Хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх үйлчлэгч нарын үүрэг

- 4.1. Халдвартай хог хаягдлыг цуглуулахдаа хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмссөн байх /халад, бээлий, малгай, амны хаалт/
- 4.2. Халдвартай хог хаягдлыг зориулалтын дугуйтай тэргэнцэрт цуглуулах
- 4.3. Халдвартай хог хаягдлыг ил задгай орхиж, ил барьж явахгүй байх
- 4.4. Халдвартай хог хаягдлыг цуглуулахдаа тасаг нэгжийн нэрийг тавьж наах
- 4.5. Аюулгүй хайрцгийг ил задгай орхиж болохгүй.
- 4.6. Аюулгүй хайрцгийг энгийн хог хаягдалтай хамт зөөвөрлөхгүй байх
- 4.7. Энэ төрлийн хог хаягдлыг шахаж, нягтруулж, сэгсэрч болохгүй.
- 4.8. Хүрэн өнгийн ууттай хог хаягдлыг бусад төрлийн хог хаягдалтай хольж болохгүй

- 4.9. Хог хаягдал тээвэрлэх тэргэнцэр, савыг өдөр бүр ажил дууссаны дараа угааж, халдваргүйжүүлнэ.
- 4.10. Халдвартай хог хаягдлын сав, тэргэнцрийг хүний хөл хөдөлгөөнтэй газарт тавьж орхихгүй.

Тав. Аюултай хог хаягдлын цэгт мөрдөх үүрэг

- 5.1. Хог хаягдлыг 0,1-120 кг хүртэл жинлэх боломжтой тавцантай, электрон жинтэй байх
- 5.2. Электрон жинг жил бүр стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулах
- 5.3. Хог хаягдал хариуцсан ажилтан нь хувийн хамгааллын хувцас хэрэгслээр /малгай, амны хаалт, нүдний шил, халад, гутал, бээлий/ бүрэн хангагдсан байна.
- 5.4. Сэргээн засах төв нь аюултай хог хаягдлыг түр хадгалах цэгтэй байна.
- 5.5. Химийн хог хаягдлын тасаг нэгжээс түр хадгалах цэг рүү хүрэн өнгийн саванд хийж зөөвөрлөн, химийн бодисын хог хаягдал хадгалах шүүгээнд хийнэ.
- 5.6. Хагарсан, шатсан өдрийн гэрэл, чийдэнг өдрийн гэрэл хадгалах саванд хаях.
- 5.7. Эмнэлгийн хог хаягдал хүлээн авах өрөөнд хог хаягдал хариуцсан ажилтан батлагдсан цагийн хуваарийн дагуу кабинет бүрээс зөөвөрлөсөн эмнэлгийн аюултай хог хаягдлыг жинлэн авч, бүртгэлийн маягтын дагуу өдөр бүр бүртгэл хөтөлж хүлээн авна.
- 5.8. Халдвар хяналтын багийн ахлагч нь аюултай хог хаягдлын мэдээг Эрүүл мэндийн сайдын 505 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын хүснэгт 5-ийн дагуу сар бүрийн 5-ны дотор Нийслэлийн эрүүл мэндийн газар болон ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны албанд цахимаар хүргүүлнэ.
- 5.9. Сэргээн засах төвийн хог хаягдал хариуцсан ажилтан нь 7 хоног бүрийн Лхагва гаригт эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын бүртгэлийн маягтын дагуу “Элемент” ХХК-ны хүлээн авагчид хүлээлгэн өгч тээвэрлүүлнэ.
- 5.10. Эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалах байранд 15:00-15:30 цагийн хооронд хүлээн авч, 15:30-16:00 цагийн хооронд цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Эмийн хог хаягдлыг устгах

- 6.1. Хугацаа дууссан, сав баглаа нь гэмтсэн бол үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч,

хандивлагчид эргүүлэн буцаана.

- 6.2. Хоргүй эмийн бодис тухайлбал, витамин, давс, глюкозын уусмал, нүдний дусаалга гэх мэтийг бохирын шугамд асгана.
- 6.3. Эмийн хог хаягдлыг хариуцсан ажилтан эмийн устгалыг акт бүрдүүлэн “Элемент” ХХК-д хүлээлгэн өгнө.

Долоо. Хог хаягдлын цэгийг цэвэрлэж, халдваргүйтгэх

- 7.1. “Элемент” ХХК хог хаягдлыг ачиж тээвэрлэсний дараа үйлчлэгч нар хог хаягдлын цэгийг хуваарийн дагуу цэвэрлэнэ.
- 7.2. Хог хаягдлын цэгийн халдваргүйжүүлэлтийг 0,1%-ийн жавелионы уусмалаар хийж гүйцэтгэнэ.

Найм. Хүлээх хариуцлага

- 8.1. Халдвар хяналтын багийн ахлагч хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэн, тасаг нэгж дэхь хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 9.1. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, түр хадгалах, халдваргүйтгэх, тээвэрлэх, устгах журмыг зөрчсөн эмч, эмнэлгийн ажилтнуудыг ХСХ-ын багийн хурлаар авч хэлэлцэн хариуцлага хүлээлгэнэ.